

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: НТАГ-2026/149/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalq@audit.gov.mn">nandinjargalq@audit.gov.mn</a></p> <p>Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал Ж.Бямбажав Утас: 11-325262 Цахим хаяг: <a href="mailto:dum_audit@yahoo.com">dum_audit@yahoo.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	4
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b> .....	4
<b>2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан</b> .....	5
<b>2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	6
<b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	7
<b>2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний     гүйцэтгэл</b> .....	8
3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 688  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Д.ЖАВХЛАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд 35,136. сая төгрөгийн орлого бүрдүүлж, 34,820.1 сая төгрөгийн зардал гаргаж 316.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ байгуулагдаж 2024 оны 6 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

### Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	455,396,845.29	458,007,877.12
1.1.02	Дансны авлага	2,536,308,802.00	700,000.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	139,083.62	85,378.00
1.1.04	Бусад авлага	12,272,708.15	114,317,110.18
1.1.06	Бараа материал	1,176,249,940.12	1,590,657,033.21
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	1,456,051,764.03
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,180,367,379.18	3,619,819,162.54
1.2.01	Үндсэн хөрөнгө	30,125,287,329.45	26,825,302,859.46
1.2.02	Биет бус хөрөнгө	13,090,000.00	10,780,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,138,377,329.45	26,836,082,859.46
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>34,318,744,708.63</b>	<b>30,455,902,022.00</b>
2.1.1.01	Дансны өглөг	1,365,499,871.76	1,084,717,362.74
2.1.1.02	Цалингийн өглөг	44,852,939.45	85,516,800.03
2.1.1.03	Татварын өр	312,806,023.00	717,618,550.60
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	377,563,886.81
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	5,197,196.29
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,723,158,834.21	2,270,613,796.47
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	26,909,227,609.00	21,138,583,651.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	26,909,227,609.00	21,138,583,651.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	28,632,386,443.21	23,409,197,447.47
2.3.01	Өмч: - төрийн	658,562,912.38	658,562,912.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	2,228,166,667.20	3,753,505,097.20
2.3.09	Хуримтлагдсан ашиг	2,799,628,685.84	2,634,636,564.95
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	285,007,879.11
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	2,799,628,685.84	2,349,628,685.84
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,686,358,265.42	7,046,704,574.53
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>34,318,744,708.63</b>	<b>30,455,902,022.00</b>

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	15,594,561,675.95	34,502,613,289.57
02	Борлуулалтын өртөг	9,881,694,014.53	25,503,908,404.49
03	Нийт ашиг( алдагдал)	5,712,867,661.42	8,998,704,885.08
05	Хүүний орлого	8,571,113.45	9,977,160.98
08	Бусад орлого	-	624,135,929.06
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>8,571,113.45</b>	<b>634,113,090.04</b>
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	1,100,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,602,378,554.68	9,292,334,260.45
12	Бусад зардал	6,625,511.35	22,708,293.44
12.1	Зардлын дүн	2,609,004,066.03	9,316,142,553.89
18	Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)	3,112,434,708.84	316,675,421.23
19	Орлогын татварын зардал	312,806,023.00	31,667,542.12
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,799,628,685.84	285,007,879.11
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>2,799,628,685.84</b>	<b>285,007,879.11</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>01</b>	<b>2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>658,562,912.38</b>	-	-	<b>658,562,912.38</b>
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,799,628,685.84	2,799,628,685.84
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	2,228,166,667.20	-	2,228,166,667.20
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>09</b>	<b>2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>658,562,912.38</b>	<b>2,228,166,667.20</b>	<b>2,799,628,685.84</b>	<b>5,686,358,265.42</b>
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(450,000,000.00)	(450,000,000.00)
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	285,007,879.11	285,007,879.11
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,525,338,430.00	-	1,525,338,430.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>17</b>	<b>2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>658,562,912.38</b>	<b>3,753,505,097.20</b>	<b>2,634,636,564.95</b>	<b>7,046,704,574.53</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,652,698,277.89	34,931,359,821.75
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,011,494,871.49	10,067,086,088.30
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	51,991,267.00	53,899,245.24
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	10,532,274,660.00	23,737,414,816.27
1.1.6	Бусад мөнгөн орлого	56,937,479.40	1,072,959,671.94
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,837,301,432.60	33,241,688,686.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн	6,552,160,520.87	14,268,401,581.68
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	871,454,254.15	3,006,604,828.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	222,369,420.00	3,478,355,516.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	39,721,851.11	183,849,244.88
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,389,669,778.12	8,675,997,015.72
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	3,300.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,656,745.00	1,073,008,371.31
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	40,075,980.00	339,733,571.96
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,711,192,883.35	2,215,735,256.09
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(184,603,154.71)</b>	<b>1,689,671,134.83</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	1,237,060,103.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,237,060,103.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(1,237,060,103.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	450,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	450,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(450,000,000.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(184,603,154.71)	2,611,031.83
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>640,000,000.00</b>	<b>455,396,845.29</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>455,396,845.29</b>	<b>458,007,877.12</b>

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Х/н	2024 он	2025 он		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>15,603,132.7</b>	<b>36,590,100.0</b>	<b>35,136,726.3</b>	<b>19,532,187.6</b>	<b>2.2</b>	<b>(1,453,373.6)</b>	<b>0.9</b>
1	Смарт орлого	м.төг	758,265.7	2,379,025.5	2,227,943.7	1,469,678.0	2.9	(151,081.8)	0.9
	Санхүүжилтын орлого	м.төг	13,620,538.5	28,284,869.2	29,461,231.9	15,840,693.4	2.2	1,176,362.6	1.1
	Нөхөн олговор	м.төг	1,115,399.8	2,565,063.6	2,429,084.2	1,313,684.4	2.2	(135,979.3)	0.9
	Сургуулийн автобус	м.төг	-	255,602.1	313,137.1	313,137.1		57,535.0	1.2
	Тусгай үйлчилгээ	м.төг	-	-	71,216.2	71,216.2		71,216.2	
	Хүүгийн орлого	м.төг	8,571.1	-	9,977.1		1.2	9,977.1	
	Бусад орлого	м.төг	100,357.6	3,105,539.4	624,135.9	523,778.3	6.2	(2,481,403.5)	0.2
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>15,603,132.7</b>	<b>36,590,100.0</b>	<b>35,136,726.3</b>	19,533,593.6	2.2	(1,453,373.6)	0.9
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>12,490,698.0</b>	<b>36,264,669.4</b>	<b>34,820,050.9</b>	22,329,352.9	2.7	(1,444,618.5)	0.9
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	2,609,004.0	-	9,316,142.5	6,707,138.5	3.5	9,316,142.5	
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	3,112,434.7		<b>316,675.4</b>	(2,795,759.2)	0.1	316,675.4	
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	2,799,628.6	-	<b>285,007.8</b>	(2,514,620.7)	0.1	285,007.8	
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	450,000.0	2,915,411.6	<b>3,833,400.9</b>	3,383,400.9	8.5	917,989.2	1.3
	а/ Орлогын татварт	м.төг	312,806.0	-	31,667.5	(281,138.4)	0.1	31,667.5	
	в/ НДШ	м.төг	-	2,330,530.0	2,277,155.6	2,277,155.6		(53,374.3)	0.9
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	-	-	1,510,650.2	1,510,650.2		1,510,650.2	
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	-	13,340.0	13,927.5	13,927.5		587.50	1.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	320.00	320.00	365.00	45.00	1.1	45.00	1.1
9	Нийт цалингийн сан	м.төг	9,666,900.0	16,072,634.2	16,267,677.8	6,600,777.8	1.7	195,043.5	1.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,517.4	4,185.5	3,714.0	1,196.6	1.4	(471.50)	0.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	-	0.99	0.99	0.99		(0.00)	1.0
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>12,272,708.1</b>	-	<b>115,102.4</b>	<b>(12,157,605.6)</b>	0.01	115,102.4	
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>28,632,386,443.2</b>	-	<b>23,409,197.4</b>	<b>(28,608,977,245.7)</b>	0.00	23,409,197.4	
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	1,723,158,834.2	-	2,270,613.8	(1,720,888,220.4)		2,270,613.8	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	26,909,227,609.0	-	21,138,583.6	(26,888,089,025.3)		21,138,583.6	

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нийт 1,150,599.0 мянган төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн 1.009.666.4 мянган төгрөгийн авлага, өглөг хасах үлдэгдэлтэй илэрхийлэгдсэн байна.	1	1,009,666.4			1	1,009,666.4	1	1,009,666.4				
33,373.2 мянган төгрөгийн авлагыг хасах үлдэгдэлтэй тайлагнаж, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна	1	33,373.2	1	33,373.2			1	33,373.2				
Гурван нэр төрлийн хөрөнгөнд 102,869.1 мянган төгрөгийн элэгдэл, хорогдлыг байгуулаагүй байна.	1	102,869.1	1	102,869.1			1	102,869.1				
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3 нэрийн 4,097.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	4,097.4			1	4,097.4	1	4,097.4				
Тайлант хугацаанд 592.9 мянган төгрөгийн цаг бүртгэлийн төхөөрөмж шууд зарлагдсан байна.	1	592.9			1	592.9	1	592.9				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,150,599.0</b>	<b>2</b>	<b>136,242.3</b>	<b>3</b>	<b>1,014,356.7</b>	<b>5</b>	<b>1,150,599.0</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

### 3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 77,764.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 3,272.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 33,643.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 40,848.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. */мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гурван ажилтны 1.462.8 мянган төгрөгийн сахилгын шийтгэлийн суутгалыг суутган тооцоогүй байна.	1	1,462.8	1	1,462.8								
Урт хэмжигч хэрэгсэл, аяганы сэт, А сунадаг шат зэргийг худалдан авч зарлагдсан байна.	1	1,810.0	1	1,810.0								
Сахилгын шийтгэлтэй 34 албан хаагчдад ажлын үнэлгээний үр дүнгийн урамшилд 12,803.5 мянган төгрөг олгосон байна	1	12,803.5			1	12,803.5						
Хүлээн авалтын зардалд 19,000.0 мянган төгрөг, сургалтын зардалд 1,840.0 мянган төгрөгийг шилжүүлж, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.	1	20,840.0			1	20,840.0						
Дизель түлш Еврд5 анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар шатахуун зарцуулсан байна.	1	25,219.3					1	25,219.3				
Үйлчилгээний ахлах ажилтан Б.Хасбаатар О.Уранбилэг нар нь анхан шатны баримтын бүрдэлгүй, ажлын тайлан гүйцэтгэл тайлагнаагүй ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн байна.	1	13,550.0					1	13,550.0				
Ординат ХХК-аас худалдан авсан 2,079.0 мянган төгрөгийн санхүүгийн программын төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тооцсон байна.	1	2,079.0					1	2,079.0				
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2 нэрийн 10,519.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.	1	-					1	-				
Татварын сайтаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварын үлдэгдлийг татан тулган шалгахад 221,976.2 мянган төгрөгийн өмнөх оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын авлагын үлдэгдэл тайлант онд хөдөлгөөнгүй хэвээр байна	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>77,764.6</b>	<b>2</b>	<b>3,272.8</b>	<b>2</b>	<b>33,643.5</b>	<b>5</b>	<b>40,848.3</b>				

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 47,665,480.2 мянган төгрөгийн зөрчлөөс 47,661,530.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3,950.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Төлбөрийн акт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" -г мөнгөн хөрөнгийн дансны журнал, харилцах дансны хуулгатай тулгахад 47,661,530.2 мянган төгрөгийн 278 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна..	1	47,661,530.2	1	47,661,530.2		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Нягтлан бодогч, нярав 2 ажилтанд хууль тогтоомжид заагдаагүй 3.950.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг олгон, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	3,950.0			1	3,950.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>47,665,480.2</b>	<b>1</b>	<b>47,661,530.2</b>	<b>1</b>	<b>3,950.0</b>